ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 25 өдөр Дугаар А/28. Бэрх хот

Ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаал байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах тайлагнах журам, Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 296 дугаар тогтоол "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам" "Татварын ерөнхий" хуулийн 41.2 дах заалт, "Нийгмийн даатгалын ерөнхий" хуулийн 7 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дах заалтын дагуу бүрэн хяналт шалгалтыг бүх төрлийн татварын ногдуулалт, төлөлтийн байдалд, хэсэгчилсэн хяналт шалгалтыг нэг буюу хэд хэдэн төрлийн татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Захирагчийн орлогч)
Нарийн бичгийн дарга: (ЗАА-ны Байгаль хамгаалагч)
Гишүүд: (ЗАА-ны Татварын улсын байцаагч)
(ЗАА-ны Газрын даамал, Батноров сумын газрын даамлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
(Батноров сумын сум дундын цагдаагийн тасгийн экологийн асуудал хариуцсан байцаагч, Цагдаагийн ахлах дэслэгч Р.Гончигсүрэн )
(Батноров сумын сум дундын цагдаагийн тасгийн жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Г.Билгүүнбаяр)
(ЗАА-ны Нийгмийн даатгалын улсын байцаагч)

2. Заагдсан хугацаанд хяналтыг чанартай зохион байгуулж, дүн мэдээг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр илтгэх хуудсаар тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (Э.Мягмарсүрэн)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ Ч.ЭНХЖАВХЛАН